

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/5/СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.bulgan@audit.mn

Булган аймаг
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
	Error! Bookmark not defined.	

1 Аудитын гэрчилгээ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.03.15 № 99

танай _____-ны № _____ т

Аудитын гэрчилгээ

ИНГЭТ ДӨЛ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.ХИШИГТ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэлэнгэ сумын “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэлэнгэ сумын “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэлэнгэ сумын “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


006020201

Үүрэг, хариуцлага

Сэлэнгэ сумын “Ингэт дөл” ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Сэлэнгэ сумын “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Хишигт-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Ингэт дөл ОНӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.03.02-наас 2020.03.5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.03.06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэт дөл ХХК нь Экологийн тэнцвэрт байдал байгалийн хаягдал модны үртсийг шахмал түлш болгон үйлдвэрлэл, цаашид үйл ажиллагаагаа өргөтгөн ажлын байр нэмэгдүүлэх, мод модон материал үйлдвэрлэж ажиллах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2017оны 06 дугаар сарын 13-ны 15 дугаар тогтоолоор Сэлэнгэ сумын “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шахмал түлш үйлдвэрлэл, зүсмэл модон материал үйлдвэрлэл

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашигладаггүй.

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөгүй) гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тохиромжтой гэж үзлээ.

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны нийт зардал 29964.5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 599.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 12 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	19367.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	

3	Албан шаардлага өгсөн	0	0.00
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
Дүн		0	19367.2

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар,

Тайланд онд хөрөө рамын орлого 10597.3 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, цалингийн зардалд 6130.0 мянган төгрөг, ажил олгогчоос НДШ-ийн зардалд 766.2 мянган төгрөг, татвар хураамж 454.8 мянган төгрөг, ашиглалтын зардалд 253.5 мянган төгрөг, бусад зардалд 3285,7 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 19074.0 мянган төгрөг нийт 29964.5 мянган төгрөгийн зардал гаргаж 19367.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сэлэнгэ сумын Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Тэргүүлэх ач холбогдол:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт

Тайланд онд хөрөө рамын орлого 10597.3 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, цалингийн зардалд 6130.0 мянган төгрөг, ажил олгогчоос НДШ-ийн зардалд 766.2 мянган төгрөг, татвар хураамж 454.8 мянган төгрөг, ашиглалтын зардалд 253.5 мянган төгрөг, бусад зардалд 3285,7 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 19074.0 мянган төгрөг нийт 29964.5 мянган төгрөгийн зардал гаргаж 19367.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.1.2 Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагаа доголдох

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлагналын зөрчил, үйл ажиллагааны доголдлыг арилгаж захирлын үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид анхаарч ажиллана.

Тэргүүлэх ач холбогдол:

3.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

Ингэт дөл ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа мянган төгрөгөөр илэрхийлсэн, өглөг авлагын тооцоолол хийгдээгүй 814.0 төгрөгийн өглөг, 553.1 төгрөгийн авлага тайланд тусгаагүйг аудитын явцад залрууллаа.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бүртгэлийг хуулийн хугацаан дотор бүрэн хөтөлж хэвших

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 20 дотор ирүүлнэ үү.

Тэргүүлэх ач холбогдол:

3.3 Бараа материалтай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт

Ингэт дөл ОНӨААТҮГ нь 2740.2 мянган төгрөгийн бараа материалын нярвын тайлан хийсэн боловч санхүүгийн тайлангийн тодруулга тайланд тусгаагүйг аудитын явцад залрууллаа.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бүртгэлийг хуулийн хугацаан дотор бүрэн хөтөлж хэвших

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 20 дотор ирүүлнэ үү.

Тэргүүлэх ач холбогдол:

3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн программ хангамжгүй байгаа нь батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн программ хангамж байхгүй нь Сангийн яамнаас тогтоосон шаардлагыг хангаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ хангамжтай болох, санхүүгийн тайлангийн бүртгэлийг хуулийн хугацаанд бүр хийж хэвших

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 20 дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ ОГНОО:

Д.АНХБАЯР ОГНОО:

П.ЭРДЭНЭЗУЛ ОГНОО:

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7164199,34</u>	<u>7040731,84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12065,64	77863,24
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0,00	0,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	12065,64	77863,24
3121	Төгрөг	12065,64	77863,24
31213	Арилжааны банк дахь харилцах	12065,64	77863,24
33	АВЛАГА	10560,30	436329,98
33401	Дансны авлага /ТӨҮГ/	10560,30	
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		436329,98
35	БАРАА МАТЕРИАЛ	7141573,40	6526538,62
351	Түүхий эд материал	0,00	0,00
354	Хангамжийн материал	7141573,40	6526538,62
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	7141573,40	6526538,62
35430	Сэлбэг хэрэгсэл		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>171666000,00</u>	<u>152592000,00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	171666000,00	152592000,00
392	Биет хөрөнгө	171666000,00	152592000,00
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88000000,00	88000000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	88000000,00	17600000,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102740000,00	102740000,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	10274000,00	20548000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>178830199,34</u>	<u>159632731,84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4989326,50</u>	<u>5159059,00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4989326,50	5159059,00
411	Богино хугацаат үнэт цаас	0,00	0,00
413	Өглөг	4943926,50	5159059,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2873703,00	4344999,00
4136	Бусад өглөг	2070223,50	814060,00
41361	Байгууллагад төлөх өглөг	2000000,00	216000,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		553100,00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	70223,50	44960,00
414	Урьдчилж орсон орлого	45400,00	0,00
41440	Бусад урьдчилж орсон орлого	45400,00	

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>173840872,84</u>	<u>154473672,84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	173840872,84	154473672,84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190740000,00	190740000,00
51101	Өмч: - төрийн	190740000,00	190740000,00
512	Хуримтлагдсан үр дүн	-16899127,16	-36266327,16
51210	Өмнөх үеийн үр дүн	-16899127,16	-16899127,16
51220	Тайлант үеийн үр дүн		-19367200,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>178830199,34</u>	<u>159632731,84</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42969554,64	10597300,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42969554,64	10597300,00
110	Орлогын албан татвар	42969554,64	10597300,00
1100	Хувь хүний орлогын албан татвар	42969554,64	10597300,00
110002	Үйл ажиллагааны орлого	42969554,64	10597300,00
110003	Хөрөнгийн орлого		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	59868681,80	29964500,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59868681,80	29964500,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59868681,80	29964500,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8711971,00	3758920,00
210101	Үндсэн цалин	8711971,00	3758920,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2596169,00	1432480,00
210201	Тэтгэврийн даатгал	2596169,00	1432480,00
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7846741,00	250143,00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	7846741,00	250143,00
2104	Хангамж, бараа материалын зардал	8362592,80	2896960,00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун	1075700,00	2535160,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	7286892,80	361800,00
2105	Нормативт зардал	0,00	0,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13277208,00	2551997,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	600000,00	
210813	Бусад зардал /ТӨҮГ/	12125900,00	2313197,00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	551308,00	238800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19074000,00	19074000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19074000,00	19074000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16899127,16	-19367200,00

Ингэт дөл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0,00	0,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0,00	0,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-16899127,16</u>	<u>-19367200,00</u>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	42969554,64	11150400,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42969554,64	11150400,00
110	Орлогын албан татвар	42969554,64	11150400,00
1100	Хувь хүний орлогын албан татвар	42969554,64	11150400,00
110002	Үйл ажиллагааны орлого	42969554,64	10597300,00
110008	Шууд бус орлого		553100,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	42966643,64	11084602,40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42966643,64	11084602,40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42966643,64	11084602,40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8711971,00	3758920,00
210101	Үндсэн цалин	8711971,00	3758920,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2596169,00	1432480,00
210201	Тэтгэврийн даатгал	2596169,00	1432480,00
210202	Тэтгэмжийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7846741,00	253543,00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	7930900,00	253543,00
2104	Хангамж, бараа материалын зардал	22215700,00	3011950,00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун	1075700,00	2535160,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	21140000,00	476790,00
2105	Нормативт зардал	0,00	0,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1596062,64	2627709,40
210803	Даатгалын үйлчилгээ	600000,00	
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	551308,00	454809,40
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	444754,64	2172900,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0,00	0,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2911,00	65797,60
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0,00	0,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2911,00	65797,60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9154,64	12065,64
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12065,64	77863,24

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190.740.000,00		-16.899.127,16	173.840.872,84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190.740.000,00	0,00	-16.899.127,16	173.840.872,84
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190.740.000,00	0,00	-16.899.127,16	173.840.872,84
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190.740.000,00	0,00	-16.899.127,16	173.840.872,84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190.740.000,00	0,00	-16.899.127,16	173.840.872,84
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-19.367.200,00	-19.367.200,00
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190.740.000,00	0,00	-36.266.327,16	154.473.672,84